

“Баргын гурван бор” уртын дуунд хийсэн шинжилгээ

Гэмпилийн Сэцэн 

Соёл урлагийн их сургуулийн Хөгжмийн урлагийн сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Дэлгэрхүүгийн Наранцацрал  

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн сургууль,
Түүх, соёл, аялал жуулчлалын тэнхим, Улаанбаатар, Монгол Улс
 narantsatsral5@gmail.com

Хураангуй: Ардын дуунд нийгэм, байгаль, ард түмний амьдрал тэмцлийн түүх, тэдний үзэл баримтлал, зан үйл зэргийг тусгаж байдаг. Барга монголчуудын ардын дуу бол өөрсдөө зохион дуулж, үеийн үед өвлөн уламжлуулсан биет бус соёлын өв билээ. Барга ардын дуунд баргачуудын мал маллах соёл, ахуйн соёл, түүхэн үйл явдал, түүхт хүмүүс, шашин шүтлэг, үзэл баримтлал, хурим найрыг багтаасан зан үйлийн талаар тусгасан байдаг бөгөөд нутаг усаа тахиж, өвөг дээдсээ хүндэлж, үр хүүхдээ энхрийлэн, энх амгаланг хүсэж, бүгдээр жаргахыг эрхэмлэдэг сэтгэлгээний төвлөрөл оршдог.

Барга уртын дууны тухай өгүүлэхэд Баргын гурван борын тухай заавал дурдах хэрэгтэй. Баргын гурван бор гэж алдаршсан “Эр бор харцага”, “Соёг бор”, “Бор бор бялуухай”-г хүмүүс хийморь сэргээх дуу гэдэг. Эдгээр дуу бол барга ардын дууны сор нь юм. Дуунуудыг бид хэв шинж, сэдэв агуулга, уламжлал залгамж чанар болон дуулах хэв маяг зэрэг хэд хэдэн талаас авч үзэхийг зорьсон. Гол онцлог нь аялгууны царааны хувьд халх, боржигон хувилбараас ялгаатай, хэл аялгууны онцлогтоо тохирсон дууны эхлэл чимэг ихтэйгээс гадна дуугаа ихэвчлэн хаялгаар төгсгөдөг, ихэвчлэн уртын дууны бэсрэг хэв шинжид хамаарна. Гэхдээ дуучны онцлог, бүтээлч чанар нөлөөтэй болохыг өвлөн уламжлагч Мягмарсүрэнгийн жишээ харуулж байна. Тэрээр эгшгийг томж дуулсан нь барга уртын дууг улам баялаг, өргөн болгожээ. Дээрх гурван дууны онцлог, аялгууны бүтэц, эгшиглэгээ, чимэглэл зэрэгт хөгжмийн шинжилгээ хийлээ.

Түлхүүр үгс: *Бор бор бялуухай, Эр бор харцага, Соёг бор, домгийн судалгаа, хөгжмийн шинжилгээ*

Analysis of the long song “Barga gurban bor”

Setsen Gempil 

School of Music Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Narantsatsral Delgerkhuu  

Department of History, Culture and Tourism,
School of Social Science and Humanities, Mongolian University of
Science and Technology, Ulaanbaatar, Mongolia

 narantsatsral5@gmail.com

Abstract: Folk songs reflect society, nature, people’s lives, history of struggles, their ideals and behaviors. Folk songs of the Barga Mongolians are an intangible cultural heritage that they composed and passed down from generation to generation. Barga folk songs reflect the rituals of the Barga people, including herding culture, household culture, historical events, historical people, religion, ideals, and weddings. There is a concentration of thought that favors sunset.

When talking about the long songs of the Barga people, it is necessary to mention the three bors of Barga. Er bor hartsaga, Soyog bor, Bor bor byalzuuhai, which are popularly known as the three bors of Barga, are called songs to cheer people up. These songs are the roots of barga folk songs. We aimed to examine these songs from several aspects, including style, subject matter, continuity of tradition, and singing style. The main feature is that they are different from the khalkh and borjigon versions in terms of their tone, and that they have a lot of ornamentation at the beginning of the song that suits their dialect characteristics, and that they often end their songs with a khayal, which is usually a minor style of long songs. However, the example of the singer’s personality and creativity is an example of the legacy of the singer Myagmarsuren. He sang the vowels with a large vowel, which made the barga urtyn song richer and broader. The characteristics of the above three songs, including the structure of the melody, intonation, and ornamentation, were analyzed musically.

Keywords: *Brown brown small bird, Man brown hawk, Soyog brown, legend studies, music analyze*

Оршил

Монголчууд байгаль ертөнц, ахуй амьдралын дундаас олон янзын домог яриа, үлгэр туульс, дуу гэх мэт ардын аман зохиолын төрөл зүйлийг зохиож, түүнийгээ аялгуулан дуулж, цоордох, хуурдах хэлбэрээр уламжилж ирсэн.

Монгол үндэстний уртын дууны дотор чухал байр суурийг эзэлж, үеийн үед уламжлагдан дуулагдаж яваа барга ардын уртын дуу нь өөрийн гэсэн хэв маягтай болжээ. Эдгээр барга ардын дууны уужуу өргөн цараа нь тал нутгийн болоод ахуй соёлын онцлогийг илэрхийлэхээс гадна бусдаас ялгарах гол онцлог нь болно (Равдан 2010).

Барга уртын дууны судалгаанд төрөл зүйл буюу агуулгаар нь хуваасан судалгаа нэлээд их байдаг. Харин Баргын гурван бор дууны талаар С.Дугарсүрэн “Хөлөн буйр - барга уртын дууны тухай өгүүлэх нь” бүтээлдээ “Баргын гурван бор дуу нь тус тусдаа өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой” (Дугарсүрэн 2010, 80) гэсэн. Багадууд Равдан “Барга ардын уртын дууны тухай өгүүлэх нь” хэмээх өгүүлэлд “... дээрх уртын дууны нугалаа чимэглэл нь голдуу тагнайн цохилгоор гаргадгаас гадна ая нь өгүүлбэрийн төгсгөл ба аяны бүрэн төгсгөлд гол аянаас доош 16-т хэмжээ, аккорд болон бага гуравцын зөөлөн аялгыг хэрэглэдэг. Тиймээс хаялга цохилго нь ганган дэгжин бөгөөд жижиг байдаг” (Равдан 2010, 405) хэмээн тэмдэглэн өгүүлсэн.

Баргын гурван бор нь “Бор бор бялзуухай”, “Эр бор харцага”, “Соёг бор” гэсэн дуунууд юм. Баргачууд бор өнгийг билэгддэг, бор өнгийг эрхэмлэдэг тул бор зүсмийн морь, бор өнгийн шувуудаар дуугаа нэрлэж дуулаагүй. Харин барга ардын дуунд үгээр зүйрлэж илэрхийлсэн байна (Равдан 2010). Бодит амьдралын үнэнийг нүдэнд үзэгдтэл тусгахын тулд бор өнгийг хэрэглэжээ. Дээрх гурван бор нь барга нутгийг төлөөлөх дуу болохоор Баргын гурван бор хэмээн тусгайлан нэрлэжээ.

Алдарт дуучин Лхасүрэн “Буяндэлгэрийн намтар” гэх номдоо “...айхтар өргөн цараатай, өндөр өнгөнд хатгаж, цайруулж дуулдаг дуу болохоор баргад бол энэ гурван дууг дуулж чаддаггүй дуучныг дуучны тоонд тооцдоггүй...” (Лхасүрэн 2016) хэмээжээ.

Судалгааны арга зүй

Баримт бичгийн шинжилгээний арга: Баримт бичгийн шинжилгээний арга нь баримт бичгийг судлах замаар баримтыг цуглуулах, тодорхойлох, ангилах, баримтын талаарх шинжлэх ухааны ойлголтыг бий болгоход хэрэглэдэг арга юм. Энэхүү аргыг ашиглан сэдэвт холбогдох ном зохиол, судалгааны бичвэрүүдтэй танилцан, дүн шинжилгээ хийв.

Анализ синтезийн арга: Бид энэхүү судалгаандаа Баргын гурван бор гэгдэх “Бор бор бялзуухай”, “Эр бор харцага”, “Соёг бор” зэрэг дуунуудыг сонгон авч хөгжмийн онолын үүднээс задлан шинжилж, нэгтгэн дүгнэсэн болно.

Хээрийн судалгааны арга: Хээрийн судалгаа нь үндэстний хөгжим судлалын судалгааны үндэс суурь болдог тул энэхүү судалгааг хээрийн судалгаанд тулгуурласан бөгөөд гүнзгийрүүлсэн ярилцлагын аргыг ашигласан болно. Хээрийн судалгааны аргаар дамжуулан Баргын гурван борын тухай товч намтар ба дууны аяыг тэмдэглэн үлдээв.

Мөн аман түүхийн судалгааны арга (*Oral history method*) зэрэг аргуудыг ашиглалаа.

Судалгааны үр дүн

I. “Бор бор бялзуухай”

“Бор бор бялзуухай” уртын дуу бол аман яруу найргийн хувьд туульсын чанартай дуу болно. Зарим эх сурвалж материалд энэ дуу эрт үед “Бор бор бялзуухай” буюу “Хүүхэн хутагтын дуу” гэж нэрлэгдэж байв хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Барга нутагт XX зууны 50-аад оноос өмнө “Зээ хүй ай” хэмээн нэрлэдэг байснаа “Баян Баргын манаа” хэмээн нэрлэх болжээ. Настай өвлөн уламжлагчид энэ дууг өдөрт нэг дуулбал тэр өдөртөө хийморьтой явна, өдөр бүр дуулбал жилдээ

хийморьтой явна гэж хуучилж байв. Иймээс энэ дуу эртнээс барга ардын уртын дууны сор нь гэдгээ нийт олонд таниулсан байжээ” (Равдан 2010, 94-95). Тус дуу нь 42 бадагтай, өргөн цараатай, хэл хэллэг нь хурц тод. Дууны эхний бадагт:

“Зээ хүй ай бор бор бялзуухай

Босохын ирнээр жиргэнэ” гэж тал нутгийн өглөөний сайхан үзэмж, үүрийн харгуйгаар болжмор шувуу жив жив гэж жиргэн шулганах сайхан байдлыг өгүүлсэн байна.

“Баян баргын адуу

Баруун хойшоо бэлчээртэй” гэсэн мөрөнд тухайн үеийн баргын адуу хаашаа бэлчдэг байсныг илтгэж,

“Баян баргын манаа

Яасан хатуу манаа вэ” гэсэн мөрөнд тэр үеийн адуу манах ажлын үүрэг хариуцлагыг дурдсан бол морь болон морины хэрэгслийн тухай:

Унасанхан морь нь

Усан тэлмэн жороотой

Тохсонхон эмээл нь

Тохой зандан бүүрэгтэй

Хазаарласанхан хазаар нь

Хавтгай мөнгөн туухайтай

Дөрөөлсөнхөн дөрөө нь

Дөрвөн матрын толгойтой

Барьсанхан ташуур нь

Бадам яргуй мөчиртэй

Чирсэнхэн уурга нь

Шилийн голын ширэвтэй

Хударгалсан хударга нь

Хоёр сайхан молцогтой” гэсэн долоон бадаг үгнээс үзэхэд, морь нь жороо, эмээл нь зандан, хазаар нь зуузайдаа мөнгөн туухайтай, дөрөө нь дөрвөн матрын толгойтой, эмээлийг нь хойш урагш буухаас сэргийлж хударга хийдэг, ташуур нь яргай, уурга нь ширэв болохыг, түүнчлэн хоёр сайхан молцогтой хэмээн нүдэнд үзэгдэм, гарт баригдам уран сайхнаар дүрсэлсэн байна. Дахин тус дууг үргэлжлүүлэн ажиглавал,

“Хоёр шөнө гэтлээ

Хойд шөнөө авлаа

Битүүний шөнө гэтлээ

Бүрхэг шөнө авлаа

Бүрхэг шөнийн жолоо

Яасан хэцүү жолоо вэ” гэж хэдэн шөнөөр гэтсэнээ хэлж, хамгийн сүүлд бүрхэг шөнө явснаа тооцож

“Авсанхан адуу нь

Гучин гурван шарга

Гучин гурван шаргын

Гурваас бусад нь жороотой

Тоолсонхон адуу нь

Дөчин дөрвөн шарга

Түүний дотор арван хоёр нь жороотой” гэж авсан адууныхаа зүс болон онцлогийг нь хэлэв. Өмссөн хувцас, эдэлсэн эдлэл хэрэгслийн тухай өгүүлэхдээ:

“Саадаг нум агссанаас нь

Сайн эр гэмээр

Санчиг үсийг нь харвал

Сайхан бүсгүй гэмээр

Хуруу гарыг нь харвал

Хүүхэн хүний шинжтэй

Хөмрөг саадгийг нь ажиглавал

Хулгайч хүний төлөвтэй

Өмссөн дээл нь

Үзүүр арьсан дотортой

Хан дарсанхан малгай нь

Халиу булган зүйдэлтэй

Саадагланхан сум нь

Сарлаг бухын эвэр

Агссанхан сум нь

Арван гурван цагаан завь

Бүсэлсэнхэн бүс нь

Бүхэл долоон шанхай

Сугалдаргалсанхан хутга нь

Цул мөнгөн эдлэлтэй” гэсэн байна.

Дахин адуугаа туугаад хаана, яаж, ямар газраар дайрч, хаа хүрснээ нэг нэгэнгүй тоочин дуулахдаа”

“Нойр муутайн гадуур

Доргиулсаар гарлаа

Нохой муутайн гадуур

Нүргүүлсээр гарлаа” гэж айл зоны хаяагаар гарах үеийн байдлаа дүрслэн,

“Гурван нохой гудайхад

Гургалдайн даваа давлаа

Долоон нохой оройлоход

Долон нуурын зээлд хүрлээ” гэж ямар газраар явж хаа хүрснээ цаг хугацаатай нь тодорхой хэлжээ.

“Танай заяа дийллээ бол

Талд нь гараад гүйцээрэй

Миний заяа дийллээ бол

Манан будан татаарай

Манхан суухад гүйцэгдвэл

Малын эзний заяа

Малгайн пүүсэнд хүрвэл

Хүүхэн миний заяа

Өргөн суухад гүйцэгдвэл

Өөрийн эзний заяа

Эмээлийн пүүсэнд хүрвэл

Хүүхэн миний заяа” гэж аз туршиж, амь тэмцэн яваагаа ингэж уянгалан дуулснаар Барга нутагт тус дууг “Хүүхэн хутагтын дуу” гэж хэлдгийн учир энэ ажээ.

Тэгвэл эдгээр дууны шүлгийг сайн ажваас, бас нэг шилийн сайн эр адууг нь хулгайлахаар хэдэн шөнөөр гэтсэн боловч адууг нь авч чадаагүй байна. Иймээс “Бор бор бялзуухай” бол баатарлаг туульсын шинжтэй, талын сайн эрийн дүрд хувирсан хүүхэн хүний магтаал дуу юм (Равдан 2010, 95) гэсэн өөр нэгэн хувилбар байна. Энэ ухаалаг хүүхэн алс холын харь нутгаас баян ноёдын адууг хөөн туугаад өөрийн нутгийнхаа ядуу зүдүү ардад хуваан өгдөг тул нутгийнхан түүний зориг, ухаан самбааг нь бахархахдаа тухайн үед хамгийн эрдэм чадалтай хэмээн бишрэгдэж байсан хутагт ламтай зүйрлэн “Хүүхэн хутагт” гэж нэрийдсэн. Тус дуун дотор:

Шарга морины минь сайныг

Аав ээж минь ер мэдээгүй

Савияа¹ гутлын хүйтнийг

Ээж минь ер ажраагүй

Хүрье гэсэн газартаа

Хүч мэдэн хүрлээ

Очъё гэсэн газартаа

Ухаанаараа хүрлээ

Бараан бүрхэг шөнийн

Батгана яасан хэцүү вэ

Баян сайн хүүгийн

Манаа нь яасан хэцүү вэ” гэх зэрэг үг байдаг. Иймээс тус дууны үг нь барга ардын дуунаас баялаг үгтэй, олон бадагтай, охь манлай дуу болно.

Бидний дараагийн нэг хувилбар бол дуучин Мягмарсүрэнгийн дуулсан “Хүүхэн хутагтын дуу” гэх баргын бэсрэг дуу юм. Энэ дууг “Баян баргын манаа” гэж өөрөөр нэрлэх тохиолдол бий. Дууны аялгуу мөн л хагас түрлэг. Нооттой хавсарган арван гурван бадаг шүлэг тэмдэглэгдсэн ба шүлгийн агуулга, хүлээсэн, цөхөрсөн аястай дуу юм.

Зээ хө

Бор борын бялзуухай

Босохынхоо эринээр жиргэнэ.

Зээ хө

Баян баргын адуу нь

Баруун хойшоо бэлчинэ..... (Чүлтэм 2015)

Ноот тэмдэглээнд тэмдэглэсэн амьсгаа авалтууд тухайлбаруудын зааг болж байна (Зураг 1). Дуучин Мягмарсүрэнгийн дуулсныг эгшиг тэмдэглэгээнд буулган, хөгжмийн задлал хийлээ.

¹ Савияа гутал – арьсан гутал

Хүүхэн хутагтын дуу

Мягмарсүрэнгийн дуулснаар



Зураг 1. Дуучин Мягмарсүрэнгийн дуулсан “Хүүхэн хутагтын дуу” баргын бэсрэг дуу

Эгшиг тэмдэглэгээнд тэмдэглэгдсэнээр, хэлбэрийн томьёолол $a+(b+c)+(d+e)$ гэсэн өгүүлбэр бүр шинэ аялгуутай, өмнөтгөл /оршилтой/ энгийн мөчлөгийн бүтэцтэй болно. “Зээ хө ай” гэсэн аялгатай дууны эхлэл оршлын үүрэгтэй боловч хагас түрлэг бүрийн /бадаг бүрийн/ өмнө дуулах тул өмнөтгөл гэж тодотгож байна.

Аялгууны цараа бага наймцын ля эгшгээс хоёрдугаар наймцын ми эгшиг хүртэл ($a-e^2$) наймц давсан тавц байгаа нь бэсрэг дууны дундаж цараа билээ (Зураг 2).



Зураг 2. Дуучин Мягмарсүрэнгийн дуулсан “Хүүхэн хутагтын дуу” баргын бэсрэг дууны цараа

“Баян баргын манаа” буюу “Хүүхэн хутагтын дуу”-ны аялгуу бага наймцын ля эгшгээр эхлээд хоёрдугаар наймцын ми эгшиг дээр төгсжээ.

Эхний оршил болох /a/ тухайлбарт, эгшиг дараалсан хөдөлгөөнөөр өгссөөр оргил эгшигт хүрчээ. Оргил эгшиг хоёр, гурав дахь /b, c/ тухайлбараас бусад тухайлбаруудад дуулах нь дууны оргилуун, тэмүүлсэн дүрслэлийг илэрхийлж байна гэж бид үзэж байна. Гурав дахь тухайлбар шууд, бусад тухайлбарт доод чалх руу буюу бага наймцын ля (a) эгшиг рүү үсрэлтээр хүрч “бязуухай” (“болжмор”) үгтэй дуулагдах нь энэ хэсэг дууны өгүүлэмжийн гол цөм болохыг тодотгожээ.

Бага наймцын ля эгшиг рүү зургаан үсрэлт, дээд оргилоос уруудах тавц үсрэлт, дөрөвдүгээр тухайлбарт /d/ дээд оргил руу өгсөх зургаан үсрэлт зэрэг холын үсрэлтүүд дууны аялгыг тодруулахаас гадна дууг тогтворгүй, сэтгэл хөдөлгөсөн, тэмүүлэлтэй хэв шинжтэй болгожээ.

Суурь эгшиг фадиез тул аялгууны эгшгийн эгнээ фадиез, ля, си, додиез, ми гэсэн таван эгшигт (fis, a, h, cis, e) буюу өрнийн бага хөгийн хандлагатай таван эгшигтийн II төрөл (Зураг 3).



Эр бор харцага нь
Жигүүр юундаа хүчтэй дээ ай яа
Идэр залуу насандаа
Даан ч ажиггүй өнгөрөөлөө ай яа.....

Эгшиг тэмдэглээнд тэмдэглэсэн гүнзгий амьсгаа авалтууд тухайлбаруудын зааг болж байна (Зураг 4). Дуучин Мягмарсүрэнгийн дуулсныг эгшиг тэмдэглэгээнд буулгасанд, таслалаар тэмдэглэгдэх амьсгаа авалтууд аянуудыг тусгаарлана.

Эр бор харцага

Мягмарсүрэнгийн дуулснаар



Зураг 4. Дуучин Мягмарсүрэн дуулсан “Эр бор харцага” барга уртын дуу

Хэлбэрийн томъёолол $(a+b)+(c+d)$ гэсэн тухайлбар бүр шинэ аялгуутай энгийн мөчлөгийн бүтэц болно.

Аялгууны цараа бага наймцын сибемоль эгшгээс хоёрдугаар наймцын соль эгшиг хүртэл $(b-g^2)$ наймц давсан зургаац байгаа нь бэсрэг дуутай харьцуулахад өргөн цараатай байна (Зураг 5).



Зураг 5. Дуучин Мягмарсүрэн дуулсан “Эр бор харцага” барга уртын дууны цараа

Дуу дунд чалханд эхлээд эхний тухайлбарт л /a/ эгшигт хоёр удаа хүрэх боловч энэ нь дууны оргил болж чадахгүй, зөвхөн чимэглэл байдлаар дуулагдаж байна. Учир нь энэ хоёр эгшиг удаан баригдалгүй 16-тын хэмнэлд маш богино дуулагдана. Мөн энэ эгшиг бусад тухайлбаруудад дахин дуулагдахгүй. Хоёр дахь /b/ тухайлбар мөн дунд чалханд эхлэх ба эгшиг дараалан уруудаад дээш “хаялга” хийсэн нь барга бэсрэг дууны онцлог болсон. Хоёрдугаар өгүүлбэрийн эхний /c/ тухайлбарт наймт хэмнэлтэй хоёрдугаар наймцын фа эгшиг дуулагдсан нь “жигүүрнээ” үгийн үргэлжлэл дэх аялгуунд байх бөгөөд энэ хэсэг дууны оргил болж байна. Энэ тухайлбарын аялгууны хөдөлгөөн, оргилоос аажмаар уруудсаар доод чалх хүрээд өмнөх тухайлбар шиг дээш чиглэх “хаялга”-аар дуусч байна. Харин сүүлийн /d/ тухайлбар доод чалхнаас дээш чиглэх хөдөлгөөн хийгээд доош наймцаар үсэрч

төгсчээ. Дууны аялгуу дунд чалханд эхлээд тэнд хөгжсөөр хоёрдугаар өгүүлбэрийн оргилоос уруудах хөдөлгөөн үргэлжилж доод чалханд дуусчээ.

Дээрх зургаац үсрэлт, дээд оргилоос уруудах тавц үсрэлт, дөрөвдүгээр тухайлбарт /d/ дээд оргил руу өгсөх зургаац үсрэлт зэрэг холын үсрэлтүүд дууны аялгыг тодруулахаас гадна дууг тогтворгүй, сэтгэл хөдөлгөсөн, тэмүүлэлтэй хэв шинжтэй болгожээ.

Суурь эгшиг до тул аялгууны эгшгийн эгнээ до, ре, фа, соль, сибемоль гэсэн таван эгшигт (с, d, f, g, b) буюу таван эгшигтийн IV төрөл (Зураг 6).



*Зураг 6. Дуучин Мягмарсүрэн дуулсан “Эр бор харцага”
барга уртын дууны эгшгийн эгнээ*

Энэ таван эгшигтийн IV төрөл, ардын дуунд ховор бөгөөд төгсгөл нь цааш үргэлжлэл байх ёстой мэт сэтгэгдэл төрүүлдэг. Мөн энэ төрлийг монголын хөгжим судлаач нар өрнө дахины их, бага хөгийн хандлага илэрдэггүй гээд “дөрөвдүгээр төрөл нэгдүгээр наймцын до, ре, фа, соль, си-b ардын хөгжимд бие даасан байдлаар маш ховор тохиолддог. Харин бусад төрөлтэй нийлэн сэлгээ хэлбэрээр тааралдах нь элбэг” (Жанцанноров 2006, 43) гэжээ. Иймд энэ “Эр бор харцага” дууны эхний өгүүлбэрт “соль” эгшиг суурь эгшиг болох тул таван эгшигтийн II төрөл, хоёрдугаар өгүүлбэрийн төгсгөлд эгшиглэгээ солигдон IV төрөл болсон байна.

Мягмарсүрэнгийн дуулсан “Эр бор харцага” дээд эгшгийг гулсаагаар хөнгөн дуулах, чимэглэл, хугалаа, нугалааг гайхалтай уран дуулсан байна.

III. “Соёг бор”

“Соёг бор” уртын дуу бол нэгэн домогчилсон шинжтэй хайр сэтгэлийн дуу юм. XIX зуунд гарсан дуу гэж нутгийн буурлууд ярьдаг. “Соёг бор” уртын дууны өөр нэгэн хувилбарыг судлаачид 1770 оны үед зохиогдсон гэж үздэг.

Тус дуунд хоёр залуугийн ариун нандин үнэнч хайр, хүүхний холыг харж, алсыг бодох оюун ухааныг магтан бор мориных нь эр шандсыг нь дурдахдаа хоёр суганд нь жигүүр ургах үлгэр домогт гардаг жигүүрт хөлгөөр дүрсэлжээ. Дууны домгийг өгүүлбэл, “Нэгэн барга залуу халхын нэг баяныд зарцлагдан байхдаа тэр баяны хүүхэнтэй хайр сэтгэлтэй болоход ээжийнхээ бие муу байгааг сонсоод, хүүхний бор үрээг унаж гэртээ харьж иржээ. Түүнийг явахад хүүхэн захижээ. “Бор үрээний сүүл нь газарт хүрсэн үед намайг эргэж ирээрэй” гэсэн тул залуу бор үрээний сүүл газар хүрэх үед хүүхнээ эргэж очих тэр үед хүүхэн харьд мордох хурим хийж байв. Ийнхүү залуу хүүхэнд ирснээ мэдэгдэж

Соёгийн бор морьтой шүү дээ
Сунжуухан шилийг туулууллаа
Сананхан бодонхон байгаад
Гэнэтхэн хүрээд ирлээ
Хөөрхөн бор морьтой шүү

Хөндийхөн шилийг тууллаа

Хэсэгхэн санан суугаад

Гэнэтхэн хүрээд ирлээ. Энэ дууны аяны цараа нь хэдийгээр өмнө нь дурдсан хоёр дуунаас их биш боловч өөр уртын дуутай харьцуулахад өргөн цараатай тул тус дууг дуулахад амьсгалаа ихээр хадгалах ур чадварыг чадамгай эзэмшсэн хүн л сайн дуулж дууны утга санааг бүрэн төгөлдөр илтгэж үзэгчдийн сэтгэлийг хөдөлгөж чадна” (Дугарсүрэн 2012-2013).

Дуучин Гэрэлсайхан дуулсан “Соёг бор” барга бэсрэг дууны аялгуу хагас түрлэг (шүлгийн хоёр мөр) бөгөөд шүлгийн агуулга нь “баяр, баясгалангийн” сэдэвтэй. “Соёг бор” дууны олон хувилбар байдаг ба морин хууртай хамсран дуулсан Гэрэлсайханы хувилбар, хагас түрлэг хоёр мөр шүлэгтэй. Аялгууны бүтэц (a+b)+(c+d)+e (Зураг 7), (Зураг 8).

Соёг бор



Зураг 7. Дуучин Гэрэлсайхан дуулсан “Соёг бор” барга дуу



Зураг 8. Дуучин Гэрэлсайхан дуулсан “Соёг бор”

Аялгууны цараа бага наймцын соль–оос хоёрдугаар наймцын соль (g – g²) хүртэл хоёр наймц байгаа нь өргөн цараатай байна. Дээд оргил эгшиг болох “соль” эгшиг нь олон дахин давтагдаж байгаа тул оргил эгшгийн үүрэгтэй байна. Дуу доод чалханд эхэлж өгүүлбэр бүр тэнд дуусч буй нь дууны агуулга буюу “далд гунигийг” дахин илэрхийлж байгаа бололтой. Харин нэмэлт (e) дэх өгсөх долооцын үсрэлт төгсгөлийн өмнөх “уриа, дуудлага” мэт сэтгэгдэл төрүүлнэ. Мөн ми эгшиг нь дууг

жаргаасан бүрэн төгсгөл болж байна. Иймд суурь эгшиг ми тул эгшигийн эгнээ ми, соль, ля, си, ре (e, g, a, h, d) (Зураг 9) буюу өрнө дахины бага хөгийн хандлагатай таван эгшигтийн II төрөл байна.



Зураг 9. Дуучин Гэрэлсайхан дуулсан “Соёг бор” барга дууны эгшигийн эгнээ

Хэлэлцүүлэг

Баргын уртын дууг үе залгамжлуулан үлдээхэд домог түүхтэй нь бичиж үлдээн, гарын авлага гаргах нь хойч үеийн судлаачдад чухал ач холбогдолтойг дээрх судалгаанаас харж болно. Гэвч тус судалгааг хийж байх явцад дараах зүйл ажиглагдлаа.

- Барга уртын дууны өвлөн уламжлагчид жилээс жилд цөөрч байна;
- Уртын дууны чиглэлээр мэргэшсэн судлаачид цөөн байна;
- Барга уртын дууны түүхэн уламжлал алдагдах эрсдэл байгаа зэргийг тодорхойллоо.

Зөвхөн дээрх гурван дууны тухайд ч биш, барга уртын дууг цаашид хэрхэн хамгаалах, уламжлалыг хадгалах талаар хэд хэдэн саналыг дэвшүүлж байна. Тухайлбал,

- Соёл, урлагийн байгууллагын түвшинд барга ардын дууны тоглолтыг зорилтот урлагийн бүтээл болгон тогтмолжуулах,
- Гурван улсын хэмжээнд барга ардын уртын болон богино дууны түүхэн, цогц судалгааг хийх шаардлагатай байна.
- Барга ардын дууны өвлөн уламжлалыг таслахгүйн тулд Хөлөнбуйрын дөрвөн малжих хошуунд дууг сэргээн хөгжүүлэх сургалт семинарыг зохион байгуулж, түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Барга ардын уртын дууны нэг онцлог бол үлгэр домгоос сэдэвлэсэн дуу олон байдаг. Баргын гурван бор хэмээх гурван дуу нь зуун зуун жилийг өнгөрүүлэхдээ ард түмний сэтгэлийг эзэмдэн хоногшсон. Хийсэн хөгжмийн шинжилгээгээ нэгтгэн дүгнэвэл,

1. Барга уртын дууны онцлог аялга нь дээш хоёрцоор, богино хэмнэлд бидний “хаялга” гэж нэрлэх хөдөлгөөнөөр төгсөж дараагийн тухайлбараас богино зогскоор тусгаарлагдсан байдаг онцлогтой байна.
2. Барга уртын дуу нь аялгууны бүтцийн хувьд аваад үзэхэд, ихэнхдээ хоёр тухайлбарт хуваагдсан өгүүлбэрийн бүтэцтэй мөчлөг хэлбэр байх бөгөөд тухайлбаруудынх нь аялгуу голдуу давтагдсан шинжтэй байна.
3. Судалгааны объект болгон сонгон авсан барга уртын дууг эгшиглэгээний хувьд шинжээд үзэхэд, ихэнхдээ таванэгшигийн 1, 4-р төрөлд дуулагдаж байна.

4. Барга уртын дуунд нугалаа хугалаа, жиргээ, чимэглэн олон янз төрлөөр хийгдэх нь элбэг байхад богино дуунд уран чимэглэл багатай, харин жигд хэмнэлтэй, эхнээсээ дуустал солигдохгүй дагнасан хэмжээтэй байна.

Ашигласан материалын жагсаалт

- Дугарсүрэн, О. 2012-2013. *Гурван борын домог. Хээрийн сурвалжлагын материалаас, гар бичмэл*. Хувийн архив.
- Дугарсүрэн, С. 2010. “Хөлөн буйр - барга ардын уртын дууны тухай өгүүлэх нь.” *Дундад улсын Монгол үндэстний уртын дууны өлгий-Шинэ барга зүүн хошууны ойллого*: 80.
- Жанцанноров, Н. 2006. *Монгол хөгжмийн таван эгшигтийн онолын асуудлууд*. Улаанбаатар.
- Лхасүрэн, М. 2016. *Буяндэлгэрийн намтар*. Хөх хот: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.
- Монгол ардын чуулга. 1992. *Монгол ардын дууны чуулган*. ӨМӨЗО: Өвөр монголын соёлын хэвлэлийн хороо.
- Равдан, Д. 2010. *Барга ардын дуу 365*. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо.
- Равдан, Д. 2010. “Барга ардын уртын дууны тухай өгүүлэх нь.” *Дундад улсын монгол үндэстний уртын дууны өлгий- Шинэ барга зүүн хошууны ойллого*: 405.
- Чүлтэм. 2015. *Барга газар усны нэртэй барга дуунууд*. Хөлөнбуйр: Барга нүүдэлчин.